



ӨМНӨГОВЬ АЙМАГ
НОМГОН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 27

Сангийндалай

Хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 33 дугаар зүйлийн 33.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн хоёрдугаар хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн Баасан гарагийн 09:00 цагт Нутгийн удирдлагын ордны "Иргэний танхим"-д эхлэн хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- 1.1. Хурлын дэг батлах тухай
- 1.2. Хурлын хороо байгуулах, түүний бүрэлдэхүүнийг сонгох тухай
- 1.3. Хурлын хороодын ажиллах журам батлах тухай
- 1.4. Сумыг 2020 онд хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай
- 1.5. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай
- 1.6. Сумын хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөө батлах тухай
- 1.7. Сумын 2020 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
- 1.8. Сумын 2020 оны төсвийн тодотгол батлах тухай
- 1.9. Сумын 2021 оны төсөв батлах тухай
- 1.10. Сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай
- 1.11. 2021 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг батлах тухай

2. Хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны дарга /Б.Булгамаа/, Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Баярмаа/ нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АДЪЯАБАТ